



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 33 (318)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Зарим хүнийг шүүгчийн албан тушаалаас огцруулсан, улируулан томилсон, чөлөөлсөн, томилсон тухай зарлигууд*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай*
- *Журамд нэмэлт оруулах тухай*
- *Төрийн бус байгууллагаар үүрэг гүйцэтгүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2003 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны есдүгээр сарын 8

№ 33 (318)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

496.	Д.Түдэвийг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай	Дугаар 149	805
497.	Ш.Оюунхандыг ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан томилох тухай	Дугаар 150	805
498.	Е.Цогтзанданг ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан томилох тухай	Дугаар 151	806
499.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 152	806
500.	А.Энхбаатарыг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 153	806

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

501.	Журам батлах тухай	Дугаар 168	806
502.	Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай	Дугаар 169	811
503.	Журамд нэмэлт оруулах тухай	Дугаар 172	811
504.	Жагсаалт, журам батлах тухай	Дугаар 173	813
505.	Төрийн бус байгууллагаар үүрэг гүйцэтгүүлэх тухай	Дугаар 174	818
506.	Зардлын норматив, жишиг батлах тухай	Дугаар 176	818

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 8 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

#### Д.Түдэвийг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Доржготовын Түдэвийг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас огцруулсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

Шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 8 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

#### Ш.Оюунхандыг ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 4, 6 дахь хэсгүүдийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

Шаравын Оюунхандыг Ховд аймаг дахь сум



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 8 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

**Е.Цогтзанданг ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан томилох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 4, 6 дахь заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Баянзүрх дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

Ёндонгийн Цогтзанданг Нийслэлийн

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 8 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

**Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 4 дэх заалт, 59 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Арвинбуянгийн Энхбаатарыг Хэнтий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Магсарын Нямжанцанг Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

Өөрөө хүсэлт гаргасан Рэнчинсамбуугийн Энхтүвшинг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, өөр албан тушаалд томилогдсон

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 8 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

**А.Энхбаатарыг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсгүүдийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

Арвинбуянгийн Энхбаатарыг Говьсүмбэр

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

1. Гадаадын иргэнийг бүртгэх, гадаадын иргэн Монгол Улсад түр болон удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух, цагаачлах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Ц.НЯМДОРЖ**

2. Энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж



## ГАДААДЫН ИРГЭНИЙГ БҮРТГЭХ, ГАДААДЫН ИРГЭН МОНГОЛ УЛСАД ТҮР БОЛОН УДААН ХУГАЦААГААР ОРШИН СУУХ, БАЙНГА ОРШИН СУУХ, ЦАГААЧЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсад албан болон хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух, цагаачлах гадаадын иргэнд зөвшөөрөл олгох, бүртгэх, зөвшөөрлийн хугацааг сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба (цаашид "Алба" гэх)-ны дүрэм болон энэхүү журмаар зохицуулна.

### Хоёр. Түр оршин суух гадаадын иргэнийг бүртгэх, бүртгэлээс хасах

2.1. Монгол Улсад түр оршин суух гадаадын иргэнийг хүлээн авсан, урьж ирүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тус тус түүнийг ирснээс хойш долоо хоногийн дотор Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд бүртгүүлэн буцахаас нь өмнө бүртгэлээс хасуулна.

2.2. Алба түр оршин суух гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг бүртгэхдээ байгууллага, аж ахуйн нэгж, иргэний албан бичиг, урилгын хуулбарыг тухайн гадаадын иргэний паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичиг (цаашид "паспорт" гэх), 3х4 см-ийн хэмжээний гэрэл зургийн хамт хүлээн авч бүртгэлийн хураамж төлүүлэн "Гадаадын иргэний бүртгэл" гэсэн мэдүүлгийн хуудас бөглүүлнэ.

2.3. Алба түр оршин суух гадаадын иргэнийг бүртгэлийн дэвтэрт овог, нэр, иргэний харьяалал, паспортын сери, дугаар, төрсөн он, сар, өдөр, хүйсийн ялгаа, оршин суух болон ажиллах байгууллага, аж ахуйн нэгжийн хаяг, утасны дугаар, ирсэн, бүртгэсэн, буцах хугацааг бүртгэж, паспортад нь бүртгэлийн дугаар, бүртгүүлсэн он,

сар, өдөр бүхий "бүртгэв" гэсэн дардас дарж, мэдээллийн санд оруулна.

2.4. Алба түр оршин суугчийг буцахад түүний паспортад нь тус улсаас гарах он, сар, өдөр бүхий "хасав" гэсэн дардас дарж, энэ тухай бүртгэлийн дэвтэр, мэдүүлгийн хуудсанд зохих тэмдэглэл хийнэ.

### Гурав. Албан хэргээр удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгох, бүртгэх

3.1. Албан хэргээр удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл авах, бүртгүүлэхэд тухайн гадаадын иргэнийг хүлээн авсан, урьж ирүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж энэ журмын 2.2-т заасан бичиг баримт бүрдүүлэхээс гадна гадаадын иргэнийг тус улсад тодорхой хугацаагаар ажиллуулах талаар төрийн захиргааны төв буюу түүний эрх олгосон байгууллагын зөвшөөрөл, оршин суугаа засаг захиргааны нэгжийн Засаг даргаас гаргасан хаягийн тодорхойлолт, гэр бүлийн гишүүдтэйгээ ирсэн бол гэрлэлтийн болон хүүхдийн төрсний гэрчилгээ буюу түүнийг орлох баримт бичгийн нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргана.

3.2. Алба оршин суух зөвшөөрөл олгож бүртгэхдээ тухайн гадаадын иргэний паспортад "зөвшөөрөл" гэсэн дардас дарж, оршин суух хугацааг тэмдэглэн бүртгэлийн дэвтэрт энэ журмын 2.3-т зааснаас гадна суралцах сургуулийн хаяг, төрийн захиргааны төв буюу түүний эрх олгосон байгууллагын зөвшөөрлийн дугаар, Албаны бүртгэлийн дугаар, оршин суух зөвшөөрлийн хугацааг нэмж бүртгэн, мэдээллийн санд оруулна.

3.3. Албан хэргээр удаан хугацаагаар оршин суугчийг буцахад нь бүртгэлээс хасч, паспортад



нь "хасав" гэсэн дардас дарж, зохих тэмдэглэл хийнэ.

3.4. Албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч болон түүний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн, захиргааны зөрчил гаргаж арга хэмжээ авахуулсан бол мэдүүлгийн хуудсанд энэ тухай тэмдэглэл хийж, мэдээллийн санд оруулна.

## **Дөрөв. Хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух, цагаачлах зөвшөөрөл олгох**

4.1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суух, цагаачлах зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа өргөдөл, хоёр үеийн намтар, боловсрол, мэргэжлийн үнэмлэх, дипломын нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, гэмт хэрэг, хэв журмын зөрчилд холбогдож байсан эсэх талаар холбогдох улсын засаг захиргааны болон цагдаагийн байгууллага (хэрэв хүсэлт гаргагч нь тус улсад оршин сууж байгаа бол тухайн баг, хорооны Засаг дарга, цагдаагийн байгууллага)-ын тодорхойлолт, дархлалын олдмол хомсдол, бэлгийн замын халдварт өвчингүй болохыг нотолсон эмнэлгийн тодорхойлолт, шинжилгээний бичиг, хөрөнгийн эх үүсвэрийн талаархи тодорхойлолт, 4х6 см-ийн хэмжээний гэрэл зураг 5 ширхэг, гэр бүл, хүүхэдтэй бол гэрлэлтийн болон хүүхдийн төрсний гэрчилгээ буюу түүнийг орлох баримт бичгийн нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг тус тус бүрдүүлж, зохих мэдүүлгийн хуудас бөглөнө.

4.2. Тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүсэлтийг Алба тагнуулын болон цагдаагийн төв байгууллагын албан ёсны саналыг харгалзан шийдвэрлэнэ.

4.3. Зөвшөөрөл олгосон гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэлд авч, хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугчийн паспортад зөвшөөрлийн дугаар, оршин суух газар (аймаг, нийслэл), хугацааг заасан тэмдэглэл бүхий

"зөвшөөрөл" гэсэн дардас дарж, байнга оршин суух, цагаачлах гадаадын иргэн, харьяалалгүй хүнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн аль нэгжийн оршин суугч болохыг нотолсон "Монгол Улсад оршин суух үнэмлэх" олгоно.

4.4. Оршин суух үнэмлэхэд тухайн байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэлийн болон регистрийн дугаар, овог, нэр, яс үндэс, иргэний харьяалал, (харьяалалгүй хүний хувьд урьд нь харьяалагдаж байсан улсын нэр), төрсөн он, сар, өдөр, хүйсийн ялгаа, оршин суух үнэмлэх олгосон он, сар, өдөр, оршин суух зөвшөөрлийн хугацаа, оршин суух хаяг, ам бүлийн байдлыг тусгана.

## **Тав. Хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суух, цагаачлах зөвшөөрлийн хугацааг сунгах, үнэмлэх үрэгдүүлсэн хүнд дахин олгох, цагаач иргэний 16 нас хүрсэн хүүхдэд оршин суух үнэмлэх олгох**

5.1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн тус улсад хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суух, цагаачлах зөвшөөрлийн хугацаа сунгуулах бол урьд нь олгосон зөвшөөрлийн хугацаа дуусахаас, хүүхдэдээ оршин суух үнэмлэх авах бол тухайн хүүхдийг 16 нас хүрэхээс тус тус нэг сарын өмнө, оршин суух үнэмлэхээ үрэгдүүлсэн буюу гэмтээсний улмаас дахин үнэмлэх авах бол хүсэлтээ 14 хоногийн дотор Албанд гаргана.

5.2. Хүсэлт гаргагч нь өргөдөл бичиж, түүнд өөрийн паспорт (харьяалалгүй хүний хувьд гадаадад зорчих үнэмлэх), оршин суух үнэмлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан эсэх тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт, хаяг, ам бүлийн байдлын тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолтыг тус тус хавсаргах бөгөөд 16 нас хүрч байгаа хүүхдэдээ шинээр оршин суух үнэмлэх авах бол мэдүүлгийн хуудас бөглөн төрсний гэрчилгээний нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, 4х6см-ийн хэмжээний 3 ширхэг гэрэл зургийн хамт бүрдүүлнэ.



5.3. Алба нь оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгах, 16 нас хүрсэн хүүхдэд оршин суух үнэмлэх шинээр олгох, оршин суух үнэмлэхийг нь хүчингүйд тооцсон тохиолдолд нөхөн олгох, оршин суух үнэмлэх сольж олгох, буцаан олгох асуудлыг шинээр зөвшөөрөл олгохтой нэгэн адил шийдвэрлэнэ.

5.4. Зөвшөөрлийн хугацааг сунгахаар шийдвэрлэсэн бол тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суух үнэмлэхэд зөвшөөрлийн дуусах хугацааг тэмдэглэх бөгөөд хувийн хэрэгт нь энэ тухай тэмдэглэл үйлдэж, мэдээллийн санд оруулна.

5.5. 55 болон түүнээс дээш насны байнга оршин суугч, цагаач гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг хугацааны хязгааргүй сунгаж болно.

### **Зургаа. Байнга оршин суух, цагаачлах зөвшөөрөл олгох болон зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах**

6.1. Алба нь Монгол Улсад хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух, цагаачлах хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүсэлтэд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэлээр буюу тагнуул, цагдаагийн төв байгууллагын саналын дагуу, зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргагчийн хувьд мөн хуулийн 10 дугаар зүйлийн 4, 5, 6 дахь хэсэгт заасныг зөрчсөн үндэслэлээр буюу тагнуул, цагдаагийн байгууллагын саналын дагуу татгалзсан хариу өгнө.

6.2. Тус улсад хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суух зөвшөөрлийн хугацааг тодорхой үндэслэлээр сунгахаас татгалзсан тохиолдолд Алба тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд "гарах" виз

олгон, тус улсаас гарч явахыг өөрт нь мэдэгдэж, түүний паспортад нь "хасав" гэсэн дардас дарж зохих тэмдэглэл хийнэ.

### **Долоо. Хяналт тавих**

7.1. Алба Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон энэхүү журмыг зөрчсөн хуулийн этгээд, иргэдэд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн дагуу торгох шийтгэл ногдуулах бөгөөд шаардлагатай бол асуудлыг нь хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

7.1.1. Энэ журмыг зөрчсөн түр оршин суугч, албан хэргээр удаан хугацаагаар оршин суугчийг Монгол Улсаас албадан гаргахааргүй байвал Алба тухайн гадаадын иргэнд "гарах" виз олгож, визийн хугацаанд тус улсаас гарахыг өөрт нь болон түүнийг хүлээн авсан, урьж ирүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд мэдэгдэж, буруутай хуулийн этгээд, иргэнд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Тухайн гадаадын иргэн визийн хугацаанд тус улсаас гарч яваагүй бол түүнийг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсаас захиргааны журмаар буюу албадан гаргах арга хэмжээ авч энэ тухай мэдээллийг мэдээллийн санд оруулна.

7.2. Алба нь байгалийн гамшиг, олон улсын хөл хориот өвчний улмаас болон мал, амьтан, ургамлын хорио цээр тогтоосон, өөрөө болон гэр бүлийн гишүүд нь удаан хугацаагаар өвчилсөн зэрэг хүндэтгэх шалтгаангүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт жилд 120 хоногоос дээш хугацаагаар байгаагүй цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүний тус улсад цагаачлан суух зөвшөөрлийг хүчингүй болгож, тухайн цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд энэ тухай бичгээр мэдэгдэх бөгөөд тухайн цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн уг шийдвэрийг эс зөвшөөрвөл мэдэгдэл хүлээн



авснаас хойш долоо хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

7.3. Алба нь оршин суух үнэмлэхийг санаатайгаар үрэгдүүлж, гэмтээсэн, болгоомжгүйгээр жилд гурав болон түүнээс дээш удаа хаяж үрэгдүүлсэн, гэмтээсэн цагаач гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух үнэмлэх дахин олгохгүй.

## Найм. Бусад зүйл

8.1. Монгол Улсад түр болон удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэмт хэрэг үйлдсэн, ял шийтгүүлсэн, захиргааны шийтгэлээр шийтгүүлсэн, ял эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн, түүнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэн өгсөн бол Алба энэ тухай мэдүүлгийн хуудсанд тэмдэглэж, мэдээллийн санд оруулна.

8.2. Албан хэргээр удаан хугацаагаар оршин суух гадаадын иргэний шууд асрамжид байдаг эцэг, эх, 18 нас хүрсэн боловч эхнэр, нөхөрт гараагүй хүүхдийг түүний нэгэн адил бүртгэнэ.

8.3. Байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн нь өөрийн улсын иргэний харьяаллаас гарсан тохиолдолд Алба түүний гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг харьяалалгүй хүний оршин суух үнэмлэхээр, харьяалалгүй хүн иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон буюу өөр улсын харьяат болсон тохиолдолд түүний харьяалалгүй хүний оршин суух үнэмлэхийг гадаадын иргэний оршин суух үнэмлэхээр сольж олгох буюу Монгол Улсын харьяат болсон бол оршин суух үнэмлэхийг хураан авч мэдээллийн санд тус тус оруулан хувийн хэрэгт нь тэмдэглэнэ.

8.4. Түр болон албан хэргээр удаан

хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг бүртгэх үйлчилгээг бичиг баримтыг бүрдүүлснээс хойш ажлын хоёр өдөрт, яаралтай үйлчлүүлэх, хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суух гадаадын иргэний паспорт, харьяалалгүй хүний үнэмлэхэд хийх тэмдэглэлийг хураамж төлснөөс хойш ажлын дөрвөн цагт, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд оршин суух үнэмлэх бичиж олгох ажиллагааг ажлын хоёр өдөрт багтаан тус тус гүйцэтгэнэ.

8.5. Алба нь тус улсад хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суух, цагаачлах гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүсэлтийг түүний бичиг баримтыг хүлээн авснаас хойш хоёр сар, оршин суух хугацаа сунгуулах, оршин суух үнэмлэх шинээр авах, нөхөн авах тухай хүсэлтийг нэг сарын хугацаанд тус тус шийдвэрлэнэ.

8.6. Хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийг нэг жил хүртэл хугацаагаар олгож, жил бүр сунгана.

8.7. Алба нь Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан ирүүлсэн хүсэлтийн хариуг албан бичгээр хүргүүлнэ.

8.8. Тус улсад хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суух, цагаачлах хүсэлт гаргагч нь холбогдох бичиг баримтыг монгол хэл дээр бүрдүүлэх бөгөөд гадаад хэлээр үйлдсэн бичиг баримтын орчуулгыг нотариатчаар гэрчлүүлсэн байна.

8.9. Алба нь тус улсад хувийн хэргээр удаан хугацаагаар болон байнга оршин суух, цагаачлахыг хүссэн гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүсэлтэд татгалзсан хариу өгөх тохиолдолд шалтгааныг тайлбарлах үүрэг хүлээхгүй.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

### Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Ардын хувьсгалын 82 жилийн ойг тохиолдуулан дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнаусугай:

1. Наваансодовын Цэнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тэргүүн дэд захирал;
2. Сонингийн Бахнаа Байгаль орчны яамны санхүү, төсвийн хэлтсийн ахлах мэргэжилтэн;
3. Адьяагийн Ариунаа Стандартчилал, хэмжил зүйн төвийн дэд дарга;
4. Очирын Энхцэцэг Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал;
5. Ёндонгийн Пүрэвцэрэн Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн дарга;
6. Ядамсүрэнгийн Мөнхжаргал "Дулааны IY цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн ашиглалтын албаны дарга;
7. Цэндийн Зоригт Цагдаагийн ерөнхий газрын Эргүүл хамгаалалтын 801

8. Цэдэн-Ишийн Болдсайхан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;
9. Дэмбэрэлийн Банзрагч Үндэсний татварын ерөнхий газрын Төвлөрсөн төсвийн орлого, хяналтын газрын татварын улсын байцаагч;
10. Эрдэнийн Эрдэнэчимэг Монголын радиогийн "Хурд" агентлагийн сурвалжлагч;
11. Самбуугийн Сайханбаяр Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн механик боловсруулалтын цехийн өнгөлгөөчин, ахлах ахлагч;
12. Лхасүрэнгийн Дэмбэрэл Увс аймгийн Малчин сумын 8 жилийн дунд сургуулийн багш;
13. Дашнямын Буянхишиг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөх;
14. Гарьдын Баасанжав "Аймаг, хотын дарга байсан ахмадуудын холбоо" Төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА

Ө.ЭНХТҮВШИН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

### Журамд нэмэлт оруулах тухай

Тэмдэгтийн хураамжийн хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2003 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 75 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын виз олгох журам"-д "Визийн хураамжийн хэмжээ" гэсэн Зургадугаар бүлгийг хавсралт ёсоор нэмж, үүнтэй холбогдуулан мөн журмын Зургаа, Долдугаар бүлгийг Долоо, Наймдугаар бүлэг болгон өөрчилж, 4.7-д "Тэмдэгтийн хураамжийн хуульд" гэснийг "Тэмдэгтийн хураамжийн хууль болон энэхүү журамд" гэж өөрчлөн найруулсугай.

2. Энэ тогтоолыг "Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд өөрчлөлт оруулах тухай" 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хууль хүчин төгөлдөр болгох өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН  
САЙД

Л.ЭРДЭНЭЧУЛУУН



## "Зургаа. Визийн хураамжийн хэмжээ

6.1. Монгол Улсад зорчих гадаадын иргэнд виз олгоход дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

6.1.1. орох буюу гарах виз олгоход тус бүр АНУ-ын 20 доллар (цаашид "ам.доллар" гэх) буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

6.1.2. орох-гарах буюу гарах-орох виз олгоход тус бүр 25 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

6.1.3. зургаан сар хүртэлх хугацааны олон удаагийн виз олгоход 65 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

6.1.4. нэг жилийн олон удаагийн виз олгоход 130 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

6.1.5. дамжин өнгөрөх нэг удаагийн виз олгоход 15 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

6.1.6. дамжин өнгөрөх хоёр удаагийн виз олгоход 30 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

6.1.7. дамжин өнгөрөх нэг жилийн хугацаатай олон удаагийн виз олгоход 50 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

6.1.8. визийн хугацааг долоо хүртэл хоногоор анх удаа сунгахад 15 ам.доллар, дараагийн хоног тутамд 2 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

6.1.9. нэг визэд хавсрагдсан иргэдийн визийг салгахад 10 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

6.2. Визийн үйлчилгээг яаралтай (8 цагийн дотор) хийх тохиолдолд 6.1-д заасан хураамжийн хэмжээг 100 хувиар нэмэгдүүлэн хураана.

6.3. Дараахь нөхцөлд гадаадын иргэнд олгох визийн хураамжийг хөнгөлөх буюу чөлөөлнө:

6.3.1. таваас арван хүний бүрэлдэхүүнтэй бүлэг жуулчны визийн хураамжийн хэмжээг 25 хувь хөнгөлөх;

6.3.2. арваас дээш хүний бүрэлдэхүүнтэй бүлэг жуулчны визийн хураамжийн хэмжээг 50 хувь хөнгөлөх;

6.3.3. харилцан адил байх зарчим баримтлан дипломат ангиллын виз олгох болон гадаад орны төр, засгийн өндөр хэмжээний айлчлалын албан ёсны бүрэлдэхүүнд орж байгаа хүмүүст олгох визийн хураамжийг чөлөөлөх;

6.3.4. гадаад орнуудын төр, засгийн албан тушаалтанд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нь төлөөний ноотоор виз олгох хүсэлт тавьсан тохиолдолд визийн хураамжаас чөлөөлөх;

6.3.5. Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу визийн хураамжаас чөлөөлөхөөр тохиролцсон бол хэлэлцээрийн дагуу ажиллах гадаадын иргэний визийн хураамжаас чөлөөлөх;

6.3.6. Монгол Улсын иргэний гадаад улсад төрсөн 16 хүртэлх насны хүүхдийг визийн хураамжаас чөлөөлөх;

6.3.7. Монгол Улсын болон тус улсад суугаа өргөмжит консул, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг визийн хураамжаас чөлөөлнө;

6.3.8. төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдсон Монгол Улсаас гарах гадаадын иргэнийг визийн хураамжаас чөлөөлөх асуудлыг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба шийдвэрлэнэ."



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

### Жагсаалт, журам батлах тухай

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5.1.5, 5.1.6, 5.1.7-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт"-ыг 1 дүгээр, "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам"-ыг 2 дугаар, "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дээрх жагсаалт, журмыг хэрэгжүүлэх

зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Улсын мэргэжлийн хяналтын газар (Д.БАТБААТАР)-т даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх асуудлаар гаргасан шийдвэрээ хянан үзэж дээрх журамд нийцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

*Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*

### УРГАМЛЫН ҮР, ҮРСЛЭГ, СУУЛГАЦ, АМЬТАН, ТҮҮНИЙ ҮР, ХӨВРӨЛ ҮР, ТҮҮХИЙ МАХ, ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН БИЧИЛ БИЕТНИЙ ӨСГӨВӨР, ЭМГЭГТ МАТЕРИАЛЫН ДЭЭЖИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ БООМТУУДЫН ЖАГСААЛТ

Нэг. Ургамлын үр, үрслэг, суулгац нэвтрүүлэх хилийн боомтууд:

1. Улаанбаатар хотын Буянт-Ухаа;
2. Дорноговь аймгийн Замын-Үүд;
3. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар;
4. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг;
5. Увс аймгийн Боршоо;
6. Дорнод аймгийн Эрээнцав;
7. Баян-Өлгий аймгийн Цагааннуур;
8. Ховд аймгийн Ярант.

Хоёр. Мал, амьтан нэвтрүүлэх болон үржлийн мал импортлох боомтууд:

1. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг;
2. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар;
3. Дорноговь аймгийн Замын-Үүд;
4. Дорнод аймгийн Хавирга;

5. Дорнод аймгийн Эрээнцав;
6. Баян-Өлгий аймгийн Цагааннуур;
7. Улаанбаатар хотын Буянт-Ухаа;
8. Хөвсгөл аймгийн Ханх;
9. Завхан аймгийн Арцсуурь;
10. Увс аймгийн Боршоо;
11. Дорнод аймгийн Ульхан;
12. Ховд аймгийн Ярант.

Гурав. Мал, амьтны үр, хөврөл үр, бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг нэвтрүүлэх болон үржлийн мал экспортлох хилийн боомтууд:

1. Улаанбаатар хотын Буянт-Ухаа;
2. Дорноговь аймгийн Замын-Үүд;
3. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг;
4. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт.



Дөрөв. Түүхий мах, дайвар бүтээгдэхүүн экспортлох боомтууд:

1. Увс аймгийн Боршоо боомт;
2. Завхан аймгийн Арцсуурь;
3. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар;
4. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг;
5. Дорнод аймгийн Эрэнцав;
6. Дорнод аймгийн Ульхан;
7. Дорнод аймгийн Хавирга;
8. Дорноговь аймгийн Замын-Үүд;
9. Улаанбаатар хотын Буянт-Ухаа;
10. Баян-Өлгий аймгийн Цагааннуур;
11. Баян-Өлгий аймгийн Өлгий;

12. Хөвсгөл аймгийн Ханх;  
13. Ховд аймгийн Ярант.

Тав. Түүхий мах, дайвар бүтээгдэхүүн импортлох боомтууд:

1. Дорноговь аймгийн Замын-Үүд;
2. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар;
3. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг;
4. Баян-Өлгий аймгийн Цагааннуур;
5. Баян-Өлгий аймгийн Өлгий;
6. Улаанбаатар хотын Буянт-Ухаа;
7. Дорнод аймгийн Эрэнцав.

**Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт**

## АМЬТАН, УРГАМАЛ, ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн /цаашид амьтан, ургамал, бүтээгдэхүүн гэх/-ийг улсын хилийн боомт, гүний гаалиар нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэх үед хорио цээрийн хяналт шалгалт хийж мал, амьтны олон улсын "А" жагсаалтын гоц халдварт өвчин, мал, амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчин, ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хөнөөлт шавьж, хог ургамал, мэрэгч амьтан /цаашид амьтан, ургамлын хорио цээртэй зүйл гэх/ хилээр нэвтрэх, дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсооход энэхүү журмын зорилго оршино.

1.2. Амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх иргэн, хуулийн этгээд, улсын мэргэжлийн хяналтын байгууллага, мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчдын хооронд үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ журамд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### Хоёр. Импортын хяналт шалгалт

2.1. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан эрх үүргийн

хүрээнд мөн хуулийн 4 дүгээр зүйлд заасан амьтан, ургамал, бүтээгдэхүүнд улсын байцаагч нь дараахь дарааллаар хорио цээрийн хяналт, шалгалт хийнэ:

2.1.1. улсын хилээр импортлож буй амьтан, ургамал, бүтээгдэхүүний импортын мэдэгдэл, экспортлогч орны хорио цээрийн гэрчилгээ, дагалдах баримт бичгийг шалгаж бүртгэх;

2.1.2. бичиг баримтын зөрчилгүй нөхцөлд импортлох амьтан, ургамал, бүтээгдэхүүн, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлд мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн үзлэг, шалгалт хийх;

2.1.3. үзлэг, шалгалтаар зөрчил илрээгүй нөхцөлд амьтан, ургамал, бүтээгдэхүүнээс стандартын дагуу дээж авч хилийн боомт дахь Мэргэжлийн хяналтын албаны дэргэдэх лабораторийн шинжилгээнд хамруулах.

2.2. Лабораторийн шинжилгээгээр хорио цээртэй зүйл илрээгүй нөхцөлд улсын байцаагч нь импортлогч иргэн, хуулийн этгээдэд мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн импортын гэрчилгээ олгон гаалийн хяналтад шилжүүлнэ.

### Гурав. Экспортын хяналт, шалгалт

3.1. Экспортлох амьтан, ургамал, бүтээгдэхүүнд улсын байцаагч нь дараахь



дарааллаар үзлэг, шалгалт хийнэ:

3.1.1. экспортлох амьтан, ургамал, бүтээгдэхүүнд эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ /сертификат/, дагалдах бичиг баримтын бүрдэлтэд хяналт, шалгалт хийж, бүртгэл хөтлөх;

3.1.2. бичиг баримтын зөрчилгүй нөхцөлд экспортлох амьтан, ургамал, бүтээгдэхүүн, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалт хийх.

3.2. Үзлэг, шалгалтаар зөрчил илрээгүй нөхцөлд мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагч нь экспортын гэрчилгээг баталгаажуулан гаалийн хяналтад шилжүүлнэ.

## **Дөрөв. Дамжуулан өнгөрүүлэх үеийн хяналт шалгалт**

4.1. Тус улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжуулан өнгөрүүлэх амьтан, ургамал, бүтээгдэхүүн нь Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

4.2. Улсын байцаагч нь дамжуулан өнгөрүүлэх амьтан, ургамал, бүтээгдэхүүний дагалдах баримт бичиг, мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн гэрчилгээ, мэдэгдэл, лац, ломбыг нэг бүрчлэн шалгаж, зөрчилгүй нөхцөлд улсын хилээр нэвтрүүлнэ.

## **Тав. Тээврийн хэрэгсэлд хийх хяналт шалгалт**

5.1. Улсын байцаагч нь хууль тогтоомжид заасны дагуу амьтан, ургамал, бүтээгдэхүүн тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл болон суудлын автомашин тус бүрт мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн үзлэг, шалгалт хийнэ.

5.2. Үзлэг, шалгалтаар хорио цээртэй зүйл илрээгүй нөхцөлд хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрч гаалийн хяналтад шилжүүлнэ.

## **Зургаа. Улсын хил дээр ариутгал, халдваргүйжүүлэлт хийх**

6.1. Улсын хилээр нэвтэрч буй амьтан,

ургамал, бүтээгдэхүүнд амьтан, ургамлын хорио цээртэй зүйл илэрвэл тэдгээрийг тээвэрлэж байгаа тээврийн хэрэгсэлд Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу ариутгал, халдваргүйжүүлэлт хийнэ.

6.2. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийхдээ Улсын мэргэжлийн хяналтын газраас баталсан зааврыг дагаж мөрдөнө.

6.3. Ариутгал, халдваргүйжүүлэлтэд шаардлагатай байгууламж, багаж, тоног төхөөрөмж, ариутгалын бодис, хөдөлмөр хамгааллын хувцсаар Улсын мэргэжлийн хяналтын газар хангана.

6.4. Улсын хил дээр хорио цээр, хязгаарлалт тогтоосон нөхцөлд ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг амьтны гоц халдварт, халдварт өвчин болон ургамлын хорио цээртэй зүйлтэй тэмцэх тус тусын зааврын дагуу хэрэгжүүлнэ.

## **Долоо. Амьтан, ургамал, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэлд илэрсэн зөрчлийг шийдвэрлэх**

7.1. Хяналт шалгалтаар амьтан, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн, бичиг баримтгүй буюу бичиг баримтын зөрчилтэй нь тогтоогдсон амьтан, ургамал, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийг хууль тогтоомжид заасан хугацаагаар саатуулна.

7.2. Саатуулагдсан амьтныг зориулалтын хашаа, байранд байрлуулж, ургамал, бүтээгдэхүүнийг зориулалтын зоорь, агуулахад хадгална.

7.3. Хяналт, шалгалтаар өвчний шинж тэмдэг илэрсэн амьтан, гадаад хорио цээртэй зүйл илэрсэн ургамал, бүтээгдэхүүнийг хуульд заасан хугацаагаар, бичиг баримтын зөрчилтэй болон бичиг баримтгүй амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг тухайн бүтээгдэхүүнээс шалтгаалан түр хугацаа (72 цаг хүртэл)-гаар тус тус саатуулна.

7.4. Улсын байцаагч нь саатуулсан амьтан, ургамал, бүтээгдэхүүний талаархи мэдээллийг цаг тухайд нь холбогдох байгууллага /Улсын мэргэжлийн хяналтын газар, Улсын гаалийн



ерөнхий газар, Төмөр замын хэрэг эрхлэх газар/, импортлогч, экспортлогч, дамжуулан өнгөрүүлэгч иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэнэ.

7.5. Саатуулсан хугацаанд зөрчлөө арилгаагүй бол амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг буцаах мэдэгдэл өгч шийдвэрлэнэ.

7.6. Амьтан, ургамал, бүтээгдэхүүнд хорио цээртэй зүйл илэрсэн нь лабораторийн шинжилгээгээр батлагдвал хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.7. Амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу экспортлогч оронд буцаасан, устгасан нөхцөлд энэ талаар үйлдсэн үндсэн баримтыг улсын байцаагч нэгтгэн Улсын мэргэжлийн хяналтын газарт ирүүлнэ.

### Найм. Бусад зүйл

8.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

### Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

## АМЬТАН, УРГАМАЛ, ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНД ЭКСПОРТ, ИМПОРТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын хилээр нэвтрүүлэх мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн (цаашид амьтан, ургамал, бүтээгдэхүүн гэх)-д экспорт, импортын гэрчилгээ (сертификат) олгох, эдгээртэй холбогдон мэргэжлийн хяналтын байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

### Хоёр. Экспорт, импортын гэрчилгээг олгох

2.1. Амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг экспортлогч иргэн, хуулийн этгээд нь хүсэлтээ хууль тогтоомжид заасан хугацаанд дор дурдсан мэдээлэл, баримт бичгийн хамт мэргэжлийн хяналтын байгууллагад ирүүлнэ:

2.1.1. амьтан, ургамал, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ;

2.1.2. худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг;

2.1.3. экспортлогч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэн бол иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

2.1.4. мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн лабораторийн шинжилгээний дүн;

2.1.5. амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл;

2.1.6. нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа;

2.1.7. амьтан, ургамал, бүтээгдэхүүний тоо, хэмжээ, боловсруулалтын байдал (хагас боловсруулсан, түүхий, хөлдөөсөн, шинэ гэх мэт), савлалт, шошго, аюулгүй байдлын талаархи мэдээлэл зэрэг дагалдах баримт бичиг.

2.2. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9, 11 дүгээр зүйл, 24.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан нөхцөлд хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн экспортын гэрчилгээг мэргэжлийн хяналтын байгууллага олгоно.

2.3. Мэргэжлийн хяналтын байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн хууль тогтоомжийн дагуу бүрдүүлсэн мэдээлэл, хүсэлтийг үндэслэн импортлох амьтан, ургамал, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл олгоно.

2.4. Мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон импортын мэдэгдэл, экспортлогч орны эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр гэрчилгээ, дагалдах баримт бичиг, хорио цээрийн үзлэг, шалгалт, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн зөрчилгүй нөхцөлд улсын хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрч улсын байцаагч импортын гэрчилгээ олгоно.

2.5. Гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, гээгдүүлсэн, үрэгдүүлсэн нөхцөлд тухайн



бараа, бүтээгдэхүүнийг давтан шинжилгээнд хамруулж дахин шинээр гэрчилгээ олгоно.

2.6. Зорчигчийн гар тээшээр авч явах амьтан, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн (1-5 кг хүртэл)-д экспортын гэрчилгээ олгоход энэ журмын 2.1 дэх заалт хамаарахгүй. Улсын байцаагч тухайн бүтээгдэхүүнд үзлэг хийж гэрчилгээ олгоно.

## Гурав. Гэрчилгээ олгохгүй байх нөхцөл

3.1. Амьтан, ургамал, бүтээгдэхүүнд гэрчилгээ олгохыг дараахь тохиолдолд хориглоно:

3.1.1. Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан шаардлага нөхцөлийг хангаагүй;

3.1.2. импортын мэдэгдэлтэй боловч экспортлогч орны эрх бүхий байгууллагын гэрчилгээгүй, эсхүл экспортын гэрчилгээтэй боловч импортын мэдэгдэлгүй;

3.1.3. амьтан, ургамлын хорио цээртэй зүйлийн шинж тэмдэг илэрсэн;

3.1.4. импортлогч орны эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг хангаагүй.

## Дөрөв. Гэрчилгээнд тавигдах шаардлага

4.1. Гэрчилгээ нь Монгол Улсаас импортлогч улстай байгуулсан гэрээ, хэлэлцээр, олон улсын амьтны халдварт өвчний болон ургамал хамгааллын байгууллагын баталсан загварт нийцүүлэн мэргэжлийн хяналтын байгууллагаас баталсан загвар, нэгдсэн дугаар, индекс, нууцлалтай байна.

4.2. Хоёр улсын гэрээ хэлэлцээрт тусгайлан заагаагүй бол экспортын гэрчилгээг англи, монгол хэл дээр, импортын гэрчилгээг монгол хэл дээр тус тус бичнэ.

4.3. Гэрчилгээг бичгийн машин буюу компьютерээр бичнэ.

4.4. Гэрчилгээг 3 хувь үйлдэж, нэг хувийг иргэн, хуулийн этгээдэд, 2 дахь хувийг тухайн боомт байрлаж буй орон нутгийн гаалийн байгууллагад, үлдсэн хувийг үндсэн материалтай нь хавсарган хадгална. Зорчигчид олгож байгаа гэрчилгээ 2 хувь байна.

4.5. Экспорт, импортын гэрчилгээг амьтан, ургамал, бүтээгдэхүүнд олгоно.

Тав. Гэрчилгээг хэвлүүлж хуваарилах, хяналт тавих

5.1. Экспорт, импортын гэрчилгээг үнэт цаас үйлдвэрлэх, хэвлэх эрх бүхий байгууллагаар хэвлүүлнэ.

5.2. Гэрчилгээг захиалах, хэвлүүлэх, хүлээн авах, дугаарлах, хадгалах, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийн тооцоо хийх ажлыг улсын мэргэжлийн хяналтын байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

## Зургаа. Гэрчилгээг баталгаажуулах

6.1. Гэрчилгээг баталгаажуулах эрх бүхий этгээдийн нэр, гарын үсэг, тэмдгийн баталгааг улсын мэргэжлийн хяналтын байгууллага батламжлан гаалийн байгууллага, хилийн мэргэжлийн хяналтын албад, аймгийн мэргэжлийн хяналтын албад хүргүүлсэн байна.

6.2. Ургамлын хорио цээрийн гэрчилгээ нь олгосон өдрөөс хойш ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эдэд 1 сар, бүтээгдэхүүнд 14 хоног, түргэн гэмтэж муудах түүхий эд, бүтээгдэхүүнд 5 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

6.3. Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ нь олгосон өдрөөс хойш мал, амьтан, тэжээлд 3 сар хүртэл, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд 5 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сар дуусталхи хугацаанд 14 хоног, 11 дүгээр сарын 1-ний өдрөөс дараа оны 4 дүгээр сар дуусталхи хугацаанд 30 хоног, түргэн гэмтэж муудах хүнсний зүйлд 3 хоногийн хүчинтэй байна.

## Долоо. Гэрчилгээг хүчингүйд тооцох

7.1. Хуурамчаар үйлдсэн;

7.2. Засварласан;

7.3. Гарын үсэг, тэмдгийг хуурамчаар үйлдсэн;

7.4. Хүчинтэй байх хугацаа дууссан;

7.5. Ачааны мэдээлэл нь дагалдах баримт бичигтэй зөрсөн;

7.6. Хадгалалтын буруугаас гэмтээсэн;

7.7. Дугаар, индекс байхгүй, эрх бүхий этгээдийн гарын үсэг, тэмдгээр баталгаажуагүй.

## Найм. Хариуцлага, бусад зүйл

8.1. Энэхүү журмыг зөрсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

### Төрийн бус байгууллагаар үүрэг гүйцэтгүүлэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол орны байгалийн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах үйл ажиллагааг "Монголын байгаль орчныг хамгаалах холбоо", "Монгол орны байгалийн ургамлыг хамгаалах "Ургамал" холбооны консорциум" төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

сэргээх, ашиглах үүргийг гүйцэтгэж байгаа консорциумын үйл ажиллагаанд зохих хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, холбогдох шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ  
САЙД

У.БАРСБОЛД

2. Байгалийн ургамлыг хамгаалах, нөхөн

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

### Зардлын норматив, жишиг батлах тухай

Боловсролын тухай хуулийн 40.2, 40.3, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 25.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативыг 1 дүгээр, төрийн өмчийн их, дээд сургууль, коллежид дээд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох сургалтын зардлын жишгийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

суралцагчид ногдох сургалтын зардлын жишгийг баримтлан сургуулийнхаа сургалтын төлбөрийн хэмжээг тогтоон мөрдөхийг төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн захирал, Удирдах зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай.

2. Цэцэрлэгийн нэг хүүхдэд улсын төсвөөс олгох хоолны зардлын хэмжээг 36000 (гучин зургаан мянган) төгрөгөөр тогтоосугай.

5. Энэхүү тогтоолоор батлагдсан норматив, зардлын жишгийг үндэслэн 2004 оны төсвийг төлөвлөж, шаардлагатай заавар, журмыг боловсруулан мөрдүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны (8 дугаар анги төгсөөд элссэн) ангийн дотуур байранд амьдрах нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 124600 (нэг зуун хорин дөрвөн мянга зургаан зуун) төгрөгөөр тогтоож төсвөөс санхүүжүүлж байсугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хувьсах зардлын нормативыг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2002 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 160 дугаар тогтоол, "Сургалтын зардлын жишиг тогтоох тухай" Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 170 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

А.ЦАНЖИД

4. Дээд боловсрол эзэмшүүлэхэд нэг

Засгийн газрын 2003 оны 176 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛЬ, МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ТӨВИЙН АНХАН ШАТНЫ АНГИЙН НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ  
ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ**

(мянган төгрөг)

№	Бүс нутаг	Аймаг, хот	Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардал	Ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардал			Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг сурагчид ногдох хувьсах зардал
				Бага анги	Дунд анги	Ахлах анги	
1	Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	100.5	66.4	82.6	88.6	159.3
2	Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	94.7	64.5	78.7	87.1	152.9
3	Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул 8. Улаанбаатар	94.1	64.1	79.5	86.6	151.8
4	Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	95.5	64.8	80.2	87.4	155.9

Тайлбар: 1. Дээрх хувьсах зардлын хэмжээнд цалингийн сангийн эзлэх хувь цэцэрлэгт 70.0 хувь, ерөнхий боловсролын сургуульд 70.0 хувь, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд 67.0 хувь байна.

2. Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дүнд хоолны зардал ороогүй болно.



Засгийн газрын 2003 оны 176 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИД ДЭЭД  
БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ  
СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ЖИШИГ**

№	Сургуулийн нэр	Зардлын жишиг /мянган төгрөг/
1	Монгол улсын их сургууль	295.0
2	Улсын багшийн их сургууль	270.0
3	Хөдөө аж ахуйн их сургууль	270.0
4	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль	315.0
5	Шинжлэх ухаан, технологийн их сургууль	296.0
6	Хүүүүчлэгийн ухааны их сургууль	280.0
7	Соёл урлагийн их сургууль	324.0
1	Дахан-Уул аймаг дахь ШУТИС-ийн салбар	210.0
2	Монгол улсын их сургуулийн Ховд аймаг дахь салбар	273.0
0	Худалдаа, үйлдвэрийн дээд сургууль	241.0
1	Дүрслэх урлагийн дээд сургууль	300.0
2	Сүхбаатар аймаг дахь ШУТИС-ийн салбар	220.0
3	Архангай аймаг дахь Багшийн коллеж	200.0
4	Баян-Өлгий аймаг дахь Багш-соёлын сургууль	200.0
5	Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны коллеж	230.0
6	Дорноговь аймаг дахь Анагаах ухааны коллеж	240.0
7	Дорнод аймаг дахь Багшийн коллеж	220.0
8	Захан аймаг дахь Эдийн засгийн коллеж	230.0
9	Дархан-Уул аймаг дахь Ургамал, газар тариалангийн хүрээлэн	260.0
0	Дархан-Уул аймаг дахь Техникийн коллеж	210.0
1	Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны коллеж	200.0
2	ЭнШУИС-ийн Сувилахуйн сургууль	200.0
3	Увсанбаатар дахь Соёлын коллеж	260.0
4	Дизайн урлагийн коллеж	260.0
5	Хөгжим бүжгийн коллеж	210.0
6	Дрнод аймаг дахь ХАА-н хүрээлэн	170.0
7	Бирлгын коллеж	170.0
8	Техник технологийн коллеж	170.0
9	Өвөрхангай аймаг дахь ШУТИС-ийн салбар	210.0
30	Увсангом коллеж	210.0
31	Хөвд аймаг дахь ХАА-н хүрээлэн	210.0
32	Үлдвэр үйлчилгээний сургууль	210.0
33	Хнсний технологийн коллеж	210.0
34	Монгол-Солонгосын хамтарсан коллеж	210.0

Талбар: 1.Энэ жишиг нь бакалаврын боловсрол олгоход мөрдөх бөгөөд дипломын боловсрол олгохд эзүү жишгээс 20 хувиар бага, магистрийн болон докторын сургалтад 20 хувиар их байхаар бодонСургалтын төрийн сангаас зээл, тусламж олгоно.

2.Төрийн өмчийн бус их, дээд сургуулийн суралцагчдад Сургалтын төрийн сангаас олгох зээл, буцалтгүйтсламж, төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг 240.0 мянган төгрөгөөр, коллежид20.0 мянган төгрөгөөр тооцож олгоно.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Жаг<<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Увсанбаатар-12  
Түрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 325487  
Хэвлэлийн хуудас 2